



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ӨРХИЙН ОРОН СУУЦНЫ
НӨХЦӨЛ ХАНГАМЖИЙН СУДАЛГАА
2019-2023 он



Улаанбаатар хот 2024 он

АГУУЛГА

	Хуудасны дугаар
1. ОРШИЛ	3
2. ЗАСАГ ЗАХИРГАА НЭГЖ	3
3. ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛД ОРШИН СУУГЧИД	6
4. ГЭР ХОРООЛОЛД ОРШИН СУУГЧИД	10
5. ДҮГНЭЛТ	14
6. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	17

Оршил

1778 онд Алтан тэвшийн хөндийд анхны сууршил эхэлсэн байна. 1926 онд Ардын цэнгэлдэх хүрээлэн буюу Бөмбөгөр ногоон сүндрэлсэн нт Улаанбаатар хотыг чимсэн хамгийн том байрилга байгууламж байв. Үүнээс өмнө одоогийн улаанбаатар зочидын хавьд 2 давхар цувраа 3 байшин байсан нь Засгийн газар, Намын хороо, Эвлэлийн хорооны барилга байв.

Улаанбаатар хотын нийт нутаг дэвсгэр 395,425-га талбайн 27409-га-д орон сууц, гэр хороололын барилгажсан бүс байдаг. Барилгажсан бүсийн 11.80 хувийг орон сууц, харин 85.20 хувь буюу дийлэнх хэсгийг гэр хороолол эзэлж байна.

2011 оны 01-р арын 01-ний байдлаар төвийн 6 дүүргийн нийтдээ 1099275 байгаагийн 424219 буюу 38.60 хувь нь орон сууцанд, 675556 буюу 61.40 хувь нь гэр хороололд оршин сууж байна. Хүн амын дундаж нягтшил орон сууцны хороололд 183 хүн/га байгаа бол гэр хороололд 26 хүн/га байна.

Сонгинохайрхан дүүрэг нь 1992 онд байгуулагдсан бөгөөд харьцангуй орон сууц цөөн дүүрэг юм. Анх дүүрэг байгуулагдахад Өнөр хороолол, 5 шар, 21-р хороолол гэсэн орон сууцны цөөн хороолол байлаа. Гэвч сүүлийн жилүүдэд орон сууцны Залуус, Хилчин хотхон, Содон, Орчлон зэрэг хороолалууд ашиглалтанд орж, орон сууцны барилга шинээр баригдаж байгаа боловч дэд бүтцийн хөгжлөөс шалтгаалан хуучин орон сууцны хорооллыг өргөжүүлэн тэлж байна. Өдгөө Сонгинохайрхан дүүрэг 43 хороотой төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Дүүргийн хүн амын нягтшил 1994 онд 1мкв талбайд 10 хүн байсан бол 2023 онд 23 болж өссөн нэмэгдсэн байна.

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ



Сонгинохайрхан дүүрэг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу зохион байгуулалтын өөрчлөлтөөр нийслэлийн Октябрийн районоос өрх тусгаарлан байгуулагдсан. Монгол Улсын Их Хурлын 1992 оны 18 дугаар тогтоолын дагуу Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 100 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр анхны хуралдаанаа 1992 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр хийжээ. Энэхүү анхны хурлаас Сонгинохайрхан дүүргийг 1992 оны 10 дугаар сарын 1-ний өдөр байгуулах тухай тогтоол гаргасан байна.

Сонгинохайрхан дүүрэг нь зүүн хойд талаараа Чингэлтэй дүүрэг, зүүн болон урд талаараа Баянгол, Хан-Уул дүүрэгтэй, баруун болон хойд талаараа Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр сумдуудтай хиллэн оршдог.

Гадаад харилцааны хувьд Япон улсын Изүнокүни хот, Күмамото хот, БНСУ-ын Пурён хот, Нонсан хот, Тэжон хотын Согу дүүрэг, Тэ-Ан хот, Кангбук дүүрэг, БНХАУ-ын Хөх хот, Хөлөнбуйр аймгийн Хайлаар дүүрэг, Хянган аймгийн Рашаан хот, Шилийн гол аймаг, Тайвань улсын Тайпэй хот, Турк улсын Истанбул хотын Шишли дүүрэг, Канад улс, Норвеги улс, Швейцарийн Холбооны Улс болон Австрали улсын Swarck, БНСУ-ын WECA, HAATZ, Япон улсын "OISCO international" зэрэг олон улсын байгууллагуудтай боловсрол-спорт, соёл-аялал жуулчлал, эдийн засаг, эрүүл мэндийн салбаруудад хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан гадаад харилцаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Тус дүүрэг нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 341.3 мянган хүн амтай, 124,3 мянган га газар нутагтай, 73.0 мянган толгой малтай, Засаг захиргааны нэгж болох 43 хороотой, нийт газар нутгийн 77 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 20 хувийг ойн сав 3 хувийг зам, шугам сүлжээ бүхий газар тус тус эзэлдэг.

Сонгинохайрхан дүүрэгт Улаанбаатар хотын нийт хүн амын 20.8 хувь, газар нутгийн 25.50 орчим хувь харъяалагддаг, нийслэлд хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ хамгийн томд ордог.

Нөгөө талаар дүүрэг нь түүх дурсгал, байгалийн үзэсгэлэнт газрууд, Хүннүгийн булш хиргисүүр олон байдаг. Тухайлбал; "Монголын нууц товчоо"-нд өгүүлдэг Хэрэйдийн Тоорил ханы сууж байсан орд өргөөний суурь нь эдүгээгийн Сонгинохайрхан дүүргийн нутаг, Сонгины булангийн доошно орших туурь мөн гэдгийг эрдэмтэд баталжээ. Хожим нь Ван ханыг дарагдсаны дараа Чингис хаан түүний Хар түнгийн ордонд өргөөлж байсан гэнэ. Мөн уг өргөөнд Чингисийн хатан Есүй, Хулан нар амьдарч байжээ гэж үздэг. 2006 онд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд Ван ханы ордны тууринд дахин малталт хийж зааны дүрс, сармагчин, арслан зэрэг дорно дахины урлагийн бэлэгдэлт дүрслэл олдсон, цаашид энэ тууринд бүрэн гүйцэт малталт хийж судалгаанд хамруулахын аялагч, жуулчдыг даллан дуудах хэтийн төлөв бий.

Сүүлийн жилүүдэд дүүргийн хүн амын тоо жил ирэх тутам өсөн нэмэгдэж байна. Хүн амын тоо өсөн нэмэгдэж байгаа нь иргэдийн газар өмчлөлтэй нягт уялдаатай бөгөөд нэг талаас гэр хорооллын өрх, хүн амын тоо нэмэгдэх эх үүсвэр болж байна. Сүүлийн 10 жилд дүүргийн хүн ам жилд дундажаар 1.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Дүүргийн газар нутгийн хэмжээ, хороогоор, га-гаар

Хороод	1994		2008		2013		2023	
	Нутаг дэвсгэрийн хэмжээ	Хүн амын нягтшил	Нутаг дэвсгэрийн хэмжээ	Хүн амын нягтшил	Нутаг дэвсгэрийн хэмжээ	Хүн амын нягтшил	Нутаг дэвсгэрийн хэмжээ	Хүн амын нягтшил
1	13 453.0	3	5 187.6	3	5 645.5	23	1 988	5
2	123.0	351	71.4	75	416.5	293	142	65
3	374.0	160	396.9	33	149.5	691	150	64
4	352.0	101	793.5	16	182.7	419	143	49
5	126.0	361	107.4	101	91.3	885	92	82
6	420.0	133	96	76	112.5	655	103	94
7	8 250.0	5	379.1	30	386.1	409	179	55
8	165.0	332	144.9	54	222.8	408	217	36
9	1 350.0	45	263.8	30	158.2	551	132	61
10	182.0	329	311.3	39	398.9	243	413	26
11	551.0	73	200.5	59	135.1	684	135	70
12	102.0	421	144.2	50	18.2	2725	19	250
13	102.0	769	51.8	144	17.7	2952	18	322
14	102.0	614	144.4	65	19.2	2742	19	302
15	102.0	652	45.2	174	18.4	2919	19	311
16	102.0	562	26.4	271	15.3	3319	15	393
17	102.0	623	78.3	87	16.5	3092	16	348
18	133.0	620	93	121	66.1	1102	35	242
19	66.0	890	49.4	201	45.8	2137	34	332
20	9 200.0	7	8 085.3	1	1 909.0	34	2 072	3
21	84 706.0	1	85 929.3	1	85 348.8	1	82 338	0
22			10 279.1	1	7 467.0	21	4 438	2
23			147.7	70	207.7	629	88	77
24			3461	2	3 476.1	32	2 969	3
25			3 576.6	3	3 519.2	34	481	20
26					878.8	170	290	36
27					27.2	1990	27	280
28					136.0	487	142	57
29					45.1	1332	45	197
30					87.3	718	83	76
31					277.1	402	185	35
32					8 509.6	3	11 738	0
33							5 746	2
34							4 911	2
35							251	22
36							602	15
37							25	356
38							70	68
39							130	49
40							211	43
41							502	16
42							3 061	2
43							93	66
Дүн	120 063.0	10	120 063.0	2	120 063.0	3	124 362	3



ОРОН СУУЦНЫ
ХОРООЛОЛД ОРШИН
СУУГЧИД


2023 оны жилийн эцсийн байдлаар нийт өрхийн 30.3 хувь нь буюу 29065 өрх байшин хороололд амьдарч байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7.5 хувиар өссөн бол 2015 онохоос 45.5 хувиар өссөн үзүүлэлт харагдаж байна.

Хүснэгт 2. Байшин хороололд амьдардаг өрх, хүн амын тоо, сууцны төрлөөр

Он	Нийт өрхийн тоо	Хүн амын тоо, бүгд	Нийтийн орон сууц		Тусдаа тохилог орон сууц		Орон гэргүй		Байшин хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь
			Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	
2015	19 975	74 176	19 947	74 082	15	75	13	19	24.1
2016	21 824	80 973	21 792	80 883	8	48	24	42	25.7
2017	22 847	82 853	22 837	82 796	10	57	0	0	26.5
2018	22 434	84 655	22 302	84 200	132	455	0	0	26.6
2019	26 624	94 611	26 581	94 452	43	159	0	0	28.5
2020	26 463	96 521	26 428	96 374	32	140	3	7	28.1
2021	26 123	99 754	26 104	99 672	16	75	3	7	29.0
2022	27 028	102 625	27 028	102 625	0	0	0	0	29.4
2023	29 065	104 020	29 065	104 020	0	0	0	0	30.3

Нийт байшин хороололд амьдардаг өрхийн 100 хувь нь нийтийн орон сууцанд амьдарч байна. 2015 оноос байшин хороололд амьдардаг хүн ам 40.2 хувиар буюу 29844 хүнээр, 2020 оноос 7.7 хувиар буюу 7499 хүнээр тус тус өссөн байна.

Зураг-1. Нийт хүн амд байшин хороололд амьдарч буй хүн амын эзлэх хувь, оноор



Нийтийн орон сууцанд амьдарч буй хүн 2015 онд нийт хүн амын 74082(24.1%) байсан бол 2019 онд 94452(28.5) хүн ам, 2023 онд 104020(30.3%) хүн ам болж өссөн нэмэгдсээр байна.

Хүснэгт 3. Нийтийн орон сууцанд амьдардаг өрх, хүн амын тоо хороогоор, оноор

Хороо	2019		2020		2021		2022		2023	
	Өрхийн тоо	Хүн амын тоо, бүгд	Өрхийн тоо	Хүн амын тоо, бүгд	Өрхийн тоо	Хүн амын тоо, бүгд	Өрхийн тоо	Хүн амын тоо, бүгд	Өрхийн тоо	Хүн амын тоо, бүгд
2	107	424	128	553	124	513	120	520	161	500
4	120	360	154	539	154	417	203	630	260	786
5	78	312	63	176	63	225	63	225	96	285
6	1 159	4 132	1 164	4 280	1 349	4 449	1 172	4 548	1 385	4 911
7	624	2 434	637	2 434	635	2 572	750	2 856	764	2 905
8	50	209	84	223	50	157	40	158	48	192
12	1 276	4 711	1 252	4 626	1 206	5 068	1 222	5 051	1 210	4 634
13	1 377	5 649	1 361	5 706	1 302	5 652	1 293	5 437	1 354	5 109
14	1 336	5 401	1 329	5 582	1 277	5 577	1 236	5 430	1 272	4 968
15	1 429	5 748	1 404	5 903	1 320	6 112	1 431	6 500	1 483	6 044
16	1 500	5 941	1 480	6 016	1 539	6 568	1 576	6 532	1 509	5 954
17	1 490	5 685	1 467	5 725	1 316	5 496	1 432	5 992	1 517	5 626
18	2 232	8 383	2 159	8 405	2 117	8 436	2 186	8 433	2 175	8 333
19	3 367	11 150	3 313	11 177	3 190	10 982	3 393	11 436	3 626	11 999
20	1 384	4 878	1 403	5 124	1 411	5 287	1 299	4 737	1 499	5 216
21	-	-	-	-	-	-	6	26	6	10
22	116	420	116	420	116	420	103	447	97	382
23	-	-	-	-	-	-	126	390	126	351
27	2 156	7 086	2 163	6 869	2 063	6 918	2 121	6 984	2 299	7 565
29	2 633	8 814	2 585	8 808	2 512	9 558	2 596	9 431	2 941	10 105
34	127	408	138	580	104	385	104	459	354	1 038
37	2 609	8 246	2 631	8 542	2 879	10 171	2 901	10 440	3 034	10 834
38	1 411	4 061	1 397	4 686	1 396	4 791	1 655	5 963	1 849	6 213
Дүн	26 581	94 452	26 428	96 374	26 123	99 754	27 028	10 2625	29 065	104 020

2023 оны байдлаар нийтийн орон сууцанд 104020 хүн буюу нийт хүн амын 30.3 хувь нь амьдарч байна. 2019 онтой харьцуулбал 9568 хүнээр буюу 9.1 хувиар, 2021 оноос 4266 хүнээр буюу 4.1 хувиар, 2022 оноос 1395 хүнээр буюу 1.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт байшин хороололд амьдардаг өрхийн 14146 өрх буюу 48.6 хувь Өнөр хороололын өрхүүд эзэлж байна.

Байшин хороололд амьдардаг өрхүүдээс хамгийн их өрх бүртгэгдсэн хороо нь 6,19, 20, 27, 29,37,38-р хороод бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4.6-18.6 хувиар өссөн бол, 34 хорооны өрхийн тоо 2 дахин өссөн байна.



ГЭР ХОРООЛОЛД
ОРШИН СУУГЧИД



2023 оны байдлаар дүүргийн нийт өрхийн 69.9 хувь буюу 66830 өрх гэр хороололд амьдарч байна. Гэр хороололд амьдарч буй өрхийн 44.1 хувь нь буюу 29475 өрх нь монгол гэрт 55.9 хувь нь буюу 37351 өрх нь байшинд тус тус амьдарч байна. Хөдөө орон нутгаас шилжих хөдөлгөөн ихсэж байгаатай холбоотойгоор дүүргийн гэр хороололын өрхүүд жилээс жилд нэмэгдэж байна. Дүүргийн нийт өрхийн тоо 2015 оноос 16.6 хувиар буюу 13000 өрхөөр, 2020 оноос 1.8 хувиар буюу 1763 өрхөөр, өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар буюу 4080 өрхөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Гэр хороололд амьдардаг өрх, хүн амын тоо, сууцны төрлөөр

Он	Нийт өрхийн тоо	хүн амын тоо, бүгд	Тохилог орон сууцанд		Байшинд амьдардаг		Монгол гэрт амьдардаг		орон гэргүй		Гэр хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь
			Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	
2015	67 247	238 253	319	1 254	35 950	129 404	30 974	107 590	4	5	81.1
2016	63 100	234 829	367	1 607	31 331	119 586	31 338	113 439	64	197	74.3
2017	63 365	239 605	248	915	32 023	126 363	31 053	112 204	41	123	73.5
2018	61 802	236 505	227	848	31 560	124 126	29 994	111 479	21	52	73.4
2019	66 897	232 969	280	1 022	35 684	128 393	30 928	103 543	5	11	71.5
2020	67 669	239 182	268	963	36 986	132 541	30 411	105 673	4	5	71.9
2021	64 108	241 786	343	1 281	33 567	129 724	30 192	110 774	6	7	71.0
2022	64 787	239 487	319	1 254	34 541	130 505	29 923	107 723	4	5	70.6
2023	66 830	237 370	155	571	37 196	137 444	29 475	99 350	4	5	70.1

Нийслэлийн гэр хороололын өрхийн амьдарлын орчинг сайжруулах төслийн хүрээнд Баянхошуу, Толгойтын гэр гэр хороололын өрхүүдийг цэвэр усны нэгдсэн сүлжээнд холбосон байна.

Нийт гэр хороололд амьдардаг өрхийн 764 өрх буюу 1.1 хувь нь био жорлонтой, 1907 өрх буюу 2.9 хувь нь бетонон болон бусад сайжруулсан бие засах газартай, 53050 өрх буюу 79.3 хувь нь бохирын цооногтой өрхүүд байна.

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн “Ногоон хөгжлийг дэмжих” ажлын хүрээнд агаар, хөрсний бохирдлыг бууруулах “Гэр хорооллын 10 мянган өрхийн нүхэн жорлонг шинэчлэх” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэн 2023 оны байдлаар нийтдээ 6700 өрхийн жорлонг бүрэн шинэчлээд байна. 2024-2028 онд төслийн 2 дахь шатыг хэрэгжүүлэн үлдсэн өрхийн нүхэн жорлонг шинэчлэн сайжруулсанаар “Хөрсний бохирдолгүй анхны дүүрэг” болох зорилтоо биелүүлэх юм.

2023 оны байдлаар гэр хороололд амьдардаг өрхийн 64.1 хувь нь ердийн галлагаатай, 4.6 хувь нь нам даралтын зуух хэрэглэдэг, 2.2 хувь нь цахилгаан халаагуур хэрэглэдэг өрхүүд тус тус амьдарч байна.

Хүснэгт 5. Байшинд амьдардаг өрх, хүн амын тоо, хороогоор, оноор

Он	2019		2020		2021		2022		2023	
	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо
1	1 869	6 344	1 869	6 344	1 345	4 833	1 561	5 601	1 496	5 343
2	1 431	5 193	1 422	5 231	1 394	5 609	1 261	4 507	1 430	4 955
3	1 692	6 941	1 692	6 941	1 493	6 372	1 668	6 965	1 880	7 236
4	1 022	3 802	1 261	4 053	1 160	4 230	1 049	4 060	1 459	4 889
5	1 164	3 859	1 256	4 138	1 181	4 592	1 181	4 204	1 211	4 068
6	1 010	3 838	1 010	3 841	710	3 376	866	3 505	866	3 814
7	1 355	5 139	1 354	5 292	1 261	5 067	1 202	5 112	1 143	4 314
8	1 454	5 336	1 408	5 230	1 306	5 147	1 269	4 905	1 631	5 778
9	1 392	4 908	1 367	4 832	1 160	4 916	1 227	4 988	1 066	4 418
10	1 645	6 653	1 798	7 326	1 721	7 296	1 671	7 210	1 775	7 561
11	1 406	6 299	1 356	5 399	1 010	4 482	1 355	5 763	1 392	5 732
19	1	4	1	4	-	-	-	-	-	-
20	335	1 129	335	1 129	329	1 158	342	1 375	399	1 445
21	1 358	4 594	1 375	3 994	1 024	3 155	1 257	3 525	1 234	3 331
22	1 412	4 332	1 482	4 655	1 503	5 400	1 467	5 414	1 441	5 254
23	1 070	3 988	1 054	4 062	953	4 062	958	3 376	1 077	3 421
24	995	3 491	1 023	3 174	1 033	3 588	1 242	4 217	1 403	4 817
25	1 508	5 475	1 503	5 572	1 637	5 603	1 568	5 657	2 039	5 826
26	1 411	4 680	1 460	4 825	1 281	4 691	1 281	4 691	1 713	5 993
27	45	157	39	360	39	367	30	285	57	236
28	1 037	4 330	1 140	4 565	1 083	4 845	1 009	4 478	1 071	4 607
30	802	2 900	804	2 920	804	3 057	792	3 324	856	3 662
31	928	3 200	973	3 534	884	3 093	863	2 974	933	3 351
32	504	1 643	596	2 234	700	2 035	700	2 069	782	2 423
33	1 416	4 450	1 624	5 282	1 533	5 467	1 637	6 016	1 598	6 393
34	1 304	4 049	1 352	4 311	1 126	4 067	1 101	3 798	1 256	4 379
35	573	2 271	573	2 271	556	2 261	555	2 396	630	2 926
36	1 210	4 166	1 234	4 206	1 171	4 450	1 123	4 040	1 205	4 065
37	29	120	29	175	29	170	15	87	15	84
38	-	-	1	3	2	9	2	8	-	-
39	956	3 241	1 022	3 761	848	3 448	843	3 431	851	3 439
40	1 226	4 064	1 231	4 263	1 105	4 461	1 085	4 313	1 243	4 447
41	757	2 843	961	3 426	937	3 619	1 068	3 941	974	4 128
42	923	3 166	861	3 204	781	3 051	813	3 020	833	3 039
43	724	2 810	788	2 947	811	3 028	799	2 504	665	2 642
Дүн	35 964	129 415	37 254	133 504	33 910	131 005	34 860	131 759	37 624	138 016

Гэр хороололд монгол гэрт амьдрахаас гадна сүүлийн жилүүдэд иргэд тохилог амины орон сууц, байшин барьж амьдрах нь ихссэн байна. 2019 оны байдлаар гэр хороололын байшинд 35964 өрхийн 129415 хүн амьдарч байсан бол 2023 оны байдлаар 36269 өрхийн 130658 хүн амьдарч байна.

Нийслэл хотод байшин барилга ихээр нэмэгдэж байгаа боловч уламжлалт монгол гэрт хүмүүс олноор амьдарч байна. 2019 онд монгол гэрт 30928 өрхийн 103543 хүн амьдарч байсан бол 2023 онд 29475 өрхийн 99350 хүн болж буурсан байна.

Гэр хороололын дахин төлөвлөлтийн хөтөлбөр, гэр хороололыг орон сууцжуулах төслийн үр дүнд гэр хороололд оршин суугчдын орчин өөрчлөгдөж эрүүл аюулгүй байдалд амьдрах нөхцөл хангагдах боломжтой болох юм.

Хүснэгт 6. Монгол гэрт амьдардаг өрх, хүн амын тоо, хороогоор, оноор

Он	2019		2020		2021		2022		2023	
	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо
1	1 043	3 139	1 060	3 222	1 219	4 460	1 090	4 150	1 272	4 213
2	1 012	3 368	1 004	3 436	917	2 946	1 032	3 596	803	2 579
3	684	2 394	679	2 627	691	3 023	616	2 325	544	2 025
4	954	2 804	650	2 415	505	2 050	568	1 807	368	1 337
5	905	3 317	825	3 185	607	2 411	639	2 318	554	1 808
6	449	1 582	424	1 576	482	2 050	468	1 901	468	1 775
7	533	1 850	552	2 034	565	2 110	469	1 951	531	2 056
8	661	2 124	661	2 303	596	2 192	699	2 660	520	1 916
9	856	3 167	846	3 191	746	2 755	606	1 980	654	1 879
10	893	3 549	800	3 260	818	3 237	787	2 726	740	2 526
11	864	2 958	908	4 118	1 116	4 960	892	3 798	1 043	3 798
19	11	45	9	46	7	25	-	-	-	-
20	226	901	226	901	308	1 151	416	1 342	316	1 071
21	852	2 209	924	3 096	1 605	4 793	1 474	4 521	1 449	4 311
22	1 721	5 299	1 638	4 954	1 659	5 710	1 588	5 352	1 501	5 189
23	927	2 753	946	2 731	814	2 543	579	2 265	467	1 749
24	1 529	4 606	1 554	5 116	1 565	5 697	1 396	5 137	1 499	4 955
25	1 082	3 530	1 235	4 014	970	4 723	1 158	4 665	980	3 915
26	1 578	5 620	1 537	5 615	1 672	5 770	1 616	5 545	1 187	3 824
27	52	185	58	347	55	400	33	157	35	157
28	1 114	3 334	1 042	3 496	918	3 005	805	2 797	851	2 851
30	872	3 313	911	3 400	759	3 470	631	2 786	545	2 051
31	951	3 305	881	2 894	821	3 202	821	3 104	818	2 773
32	796	2 155	812	1 944	957	2 777	994	2 899	1 067	3 040
33	2 302	7 273	2 219	7 156	2 118	7 441	3 440	10 980	4 017	12 613
34	1 030	3 415	1 071	3 346	930	2 992	724	2 577	714	2 487
35	848	2 944	915	3 286	847	3 126	858	3 297	913	3 002
36	1 290	4 367	1 316	4 567	1 193	4 285	1 125	4 238	1 178	4 175
37	36	175	42	160	42	166	56	260	56	204
38	4	15	9	41	10	35	9	33	5	22
39	740	2 970	698	2 586	693	2 684	643	2 542	675	2 525
40	1 320	4 873	1 317	4 746	1 251	4 445	1 216	4 296	1 008	3 594
41	1 403	4 850	1 195	4 397	1 307	4 707	1 128	4 259	1 185	3 886
42	523	2 033	655	2 301	690	2 488	706	2 369	719	2 383
43	867	3 121	792	3 166	739	2 945	641	3 090	793	2 661
Бүгд	30 928	103 543	30 411	105 673	30 192	110 774	29 923	107 723	29 475	99 350

Дүгнэлт

Өрхийн орон сууцны хангамжийг сайжруулахын тулд

- 1) Гэр хорооллыг орон сууцны цогцолбор болгон хувиргах,
- 2) Одоо байгаа гэр хорооллын нийтийн үйлчилгээний нөхцөлийг үе шаттайгаар сайжруулах
- 3) Хотын захын гэр хорооллыг цаашид өргөжүүлэн тэлэх. Гурван төрлийн гэр хороолол

(хотын төвийн, хотын ойр орчмын, хотын захын гэр хороолол) –ыг гэр хорооллыг хөгжүүлэх 3 хувилбар бий гэсэн хэдий ч бодит амьдрал дээр ихэнх гэр хороололд өндөр нягтаршилтай хөгжилд хүрэх боломжгүйд хүргэж буй олон хүндрэл байна.

- Нэгдүгээрт, хотын төвийн гэр хорооллыг орон сууцны комплекс болгоход урт хугацаа шаардлагатайгаас гадна гэр хорооллын оршин суугчдад хэт өндөр өртөгтэй тусна. Моргажийн санхүүжилт, хөрөнгийн зах зээлийг сайн хөгжүүлэх хэрэгтэй байна.

- Хоёрдугаарт, хотын ойр орчмын гэр хорооллыг нийтийн ахуйн үйлчилгээнд холбоно гэдэг хэтэрхий өндөр өртөгтэй. Жишээ нь: Нэг айлын төвийн усан хангамжийн системд холбогдох зардал 5.6-16.1 сая төгрөг, дулааны шугамд холбогдох зардал 2.8-5.6 сая төгрөг, цахилгаанд холбоход 0.28-0.56 сая төгрөг шаардагдана. Хэрвээ оршин суугчдын орлого нэмэгдвэл цөөн давхартай, инженерийн шугам сүлжээнд холбогдсон хэд хэдэн айлын орон сууц барих замаар орон байрны нөхцөлийг сайжруулах боломжтой. Тийм учраас хотын ойр орчмын гэр хорооллынхон орон байрандаа сэтгэл хангалуун байдаг ч нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулахыг хүсч байгаа одоогийн байдалд оршин суугчдын төлбөрийн чадвар, улсын төсвийн санхүүгийн боломжийн хүрээнд нийтийн ахуйн үйлчилгээг үе шаттайгаар сайжруулах нь хамгийн бодитой арга зам байна.

- Гуравдугаарт, хотын захын, алслагдсан гэр хороололынхон одоогийн орон байрны нөхцөлдөө сэтгэл тун хангалуун бус байна. Тэдний орлого бага, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муу байна. Тиймээс, тэд өөрсдийн санхүүгийн чадамжаар боломжийн газарт шилжин суурьших боломжтой. Нийтийн ахуйн үйлчилгээг хүний хамгийн наад захын хэрэгцээг хангах түвшинд байлгах хэрэгтэй.

Орон байр, газар:

- Хотын ойр орчмын гэр хороололд өртөг багатай, жижгэвтэр нийтийн орон сууц барих боломжийг судлаж үзэх хэрэгтэй. Засгийн газрын хэрэгжүүлж байгаа орон сууцжуулах хөтөлбөр нь гэр хорооллынхны хувьд хэт үнэтэй байна. Гэр хорооллын нэг өрхийн сарын дундаж хуримтлал 16800- 93800 төгрөг байхад одоогийн гэр хороололд орон сууцны дундаж үнэ 68 сая төгрөг , хувийн байшин 18.0- 29.0 сая төгрөг байна. Гэхдээ олон хүмүүс газраа нийлүүлээд нэгдсэн, цөөн давхартай нийтийн орон сууц барихыг таашааж байгаа.
- Хотын санхүү, банк санхүүгийн салбар, улмаар моргажийн зээлийн санхүүжилтийн талаар цаашид нарийвчлан судлаж үзэх ёстой. Засгийн газар маш тодорхой бодлогын чиглэлээ тодорхойлох зайлшгүй шаардлагатай. Гэр хорооллын оршин суугчдын олонхи нь ихэнх зүйлсээ өөрсдийн хувийн хуримтлалаараа санхүүжүүлдэг байна.

Хотын зам, нийтийн тээвэр:

- Олон гэр хорооллуудын газар нутаг дээрх дэд бүтцийг сайжруулж, оршин суугчдын өдөр тутмын хэрэгцээг хангах зайлшгүй шаардлагатай. Үүнд, явган хүний зам, явган гүүр, хүүхэд залуучуудын төв орно. Явган хүний замыг барьснаар агаарын чанарыг сайжруулж чадна.
- Гол замаас хороодын газар нутаг руу зам салаалан хөгжүүлэх төлөвлөгөөтэй болох хэрэгтэй байна. Эдгээр зам нь ус зайлуулах шуудуу, гудамжны гэрэлтэйгээ цогц байх ёстой. Гэр хорооллынхонд зах зээл, ажлын газар, сургууль, бусад үйлчилгээний хүртээмж харьцангуй муу байдаг. Мөн автобусны үйлчилгээ хүрэлцээгүй, найдваргүй байна. Гэр хорооллын оршин суугчдийн 58 хувь нь нийтийн тээврээр үйлчлүүлдэг, буудлаас сургууль , ажилдаа хүртэл 2,5-8,0 км явган алхаж хүрч байна.

Ус, цахилгааны хангалт

- Хотын захын хороололд ус, цахилгаан, дулаан зэрэг нийтийн ахуйн үйлчилгээг хүний хамгийн наад захын хэрэгцээг хангах түвшинд хүргэсэн байх хэрэгтэй. Одоогоор төвийн сүлжээнд холбоход хүндрэлтэй, хэт өндөр зардалтай, тэгээд ч ихэнх төвлөрсөн сүлжээнүүд бүрэн хүчин чадалдаа нэгэнт хүрчихсэн байна. Нийтийн ахуйн үйлчилгээний үнэ тогтоолт (тарифын тохируулгыг хамруулан), зохицуулалтад шинэчлэл зайлшгүй хийх шаардлагатай байна.
- Гэр хорооллын усны одоогийн тариф 1000төг (\$0.71)/м³ . Ус түгээх цэгийн нэгжийн зардал 3,200 – 4,300төг (\$2.29 – \$3.07)/м³ . Гэр хорооллын ус түгээх цэг бүр жилд 10 - 26 сая төгрөг (\$7,100-\$18,600)- ийн алдагдалтай ажиллаж байна. УБ хотын ус түгээх цэгүүдийн үйл ажиллагааг дэмжих татаасын сайн системийг хөгжүүлэх хэрэгтэй. Тэгэхэдээ ус түгээх үйл

ажиллагааны алдагдлын ихэнхийг орон сууцан дах хэрэглээний усны борлуулалт эзэлж байна. Орон сууцны усны тариф нь 167 төг /м3 байгаа нь холбогдох зардлын 50 хувьт ч хүрэхгүй байна.

- Гэр хорооллын оршин суугчид 100-110 квт цахилгаан хэрэглэж, орлогынхоо 4-5%-ийг төлдөг.

Дулаан хангамж

- Гэр хороололд цэвэр, үр ашиг өндөртэй пийшин, түлшний хүртээмжийг дээшлүүлэх хэрэгтэй . Үүний үр дүнд эрүүл мэндийн хувьд ноцтой түвшинд хүрсэн агаарын бохирдлыг бууруулах болно. Мөн орон байрны дулааны үр ашгийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай; дулаалга муутайгаас гэрийн дулаан алдалт маш өндөр байдаг.

Хатуу хог, хаягдын менежмент

- Гэр хорооллын хатуу хог, хаягдын менежментийг сайжруулах шаардлагатай. Одоогийн байгаа систем нь үр ашиггүй, найдваргүй, тогтмол бус, өртөг өндөртэй байна. Эрүүл ахуйн нөхцөл ч тун муу байна.

Нийгмийн үйлчилгээ – боловсрол, эрүүл мэнд

- Гэр хорооллын хүүхдүүдийн боловсролыг сайжруулах хэрэгтэй. Шинээр ирж байгаа сурагчдыг хамруулах нөхцөл хомс байна. Чанартай боловсрол олгох сайн багш, илүү таатай нөхцөл (зам, усан хангамж, эрүүл ахуй) гэх мэт зүйлсэд хангалттай хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Ustat.mn сайт
2. 1993-2021 оны статистикийн эмхэтгэл
3. ӨС-1 СХД-ийн статистикийн хэлтсийн албан ёсны мэдээ 2019-2023 он
4. Google.com сайт



ХЯНАСАН:

Б.Баатарцогт Сонгинохайрхан дүүргийн
Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

Г.Батцэцэг Сонгинохайрхан дүүргийн
Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн